

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

-
1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хоёр дахь хэлэлцүүлэг**/ 3-4
 2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/ 4-5

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир;

Чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: Ц.Анандбазар, Г.Мөнхцэцэг, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Саранчимэг: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 08 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 52.6 хувь бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог нэрээр та бүхэнд танилцуулъя.

Цогт-Очирын Анандбазар ирээгүй байна. Тилеуханы Аубакир томилолттой. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн ирсэн байна. Гочоогийн Ганболд гишүүн ирээгүй байна. Наянтайн Ганибал ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн ирээгүй байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирээгүй байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн ирсэн байна. Батсүхийн Саранчимэг гишүүн ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирээгүй байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн чөлөөтэй. Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар

гишүүн ирсэн байна. Гочоогийн Ганболд гишүүн ирсэн байна. Ирц 63.2 хувьтай байна.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх 2 асуудал байгаа.

Нэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ийм асуудал байгаа.

Хоёрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Тэгэхээр хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хоёрдугаар асуудлынхаа талаар хэлэлцье. Нэгдүгээр асуудлаар.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Нинжбатын Ууганбаатар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор, Хүрэлбаатарын Баасанжаргал Хүний

эрх- дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал байна.

гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө холбогдох хуулийн заалтуудыг бас уншиж та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа. Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ гаргана.

14.21 цаг

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Та бүхэн хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Танилцуулга явахгүй, явахгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулттай гишүүд байна уу? Асуулт байхгүй учраас одоо асуултаа тасалъя. Санал хураалт зарчмын зөрүүтэй саналыг бичгээр өгөх ёстой. Одоогийн байдлаар гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Алга байна. Бичгээр санал алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байхгүй учраас энэ санал хураалтыг дуусах гэж байна.

Тийм учраас дараагийнхаа асуудалд орохоос өмнө эхнийхээ энэ асуудлаар санал хураалт явуулна. Тийм ээ. Санал хураалт болох гэж байна. Сая картаа хийсэн гишүүд танхимд орж ирнэ үү.

Одоо хуулийн төслийн 2 дугаар зүйл рүүгээ оръё. Тэгэхээр 2 дугаар зүйл бол, түрүүн 2 дугаар зүйлээ танилцуулсан. Тэгэхээр 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Одоо санал хураалт.

Алга байна. Санал байхгүй байна. Бичгээр санал өгөх ёстой. Бичгээр санал ирээгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан одоо санал байхгүй учраас дараагийнхаа 3 дугаар зүйл рүү оръё.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Гишүүдийн 64.3 хувиар, 9

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүн, нэрс алга байна тасаллаа. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр ирүүлсэн санал байх ёстой. Ирээгүй байна. Санал хураалтыг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууссан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганболд танилцуулна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн эрхэм гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

14.24 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР**